

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

Г “Хай би ойл” ХК-ийн өрийг хувьцаагаар 7
сольж нэмж үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1, 7.2, Компанийн тухай хуулийн 25, 39 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.1 дэх заалт, “Хай би ойл” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2009 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хай би ойл” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог нийт 2.234.268 /хоёр сая хоёр зуун гучин дөрвөн мянга хоёр зуун жаран найман/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Бидисек” ХК-иас “Хай би ойл” ХК-д олгосон нийт 257 231 300 /хоёр зуун тавин долоон сая хоёр зуун гучин нэгэн мянга гурван зуун/ төгрөгийн зээлийн өрийг 2010 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот “Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ”-нд заасны дагуу хувьцаа тус бүрийг 174 төгрөгийн худалдах үнээр тооцон нийт 1.478.341 /нэг сая дөрвөн зуун далан найман мянга гурван зуун дөчин нэгэн/ ширхэг хувьцаагаар сольж, өмчлөх эрхийг бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. “Эм ити эф” ХХК-иас “Хай би ойл” ХК-д олгосон нийт 32 289 000 /гучин хоёр сая хоёр зуун наян есөн мянган/ төгрөгийн зээлийн өрийг 2010 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот “Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ”-ний дагуу тус бүр нэгж хувьцааг 174 төгрөгийн худалдах үнээр тооцон 185.569 /нэг зуун наян таван мянга таван зуун жаран есөн/ ширхэг хувьцаагаар сольж, өмчлөх эрхийг бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

4. Нэмж гаргах замаар нийтэд нээлттэй худалдах 570.358 /таван зуун далан мянга гурван зуун тавин найман/ ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 174 төгрөгөөр нийтэд худалдахыг зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолын 2, 3-т заасан хувьцааг зээлдүүлэгч тус бүрийн өмчлөлд шилжүүлэх болон энэ тогтоолын 4-т заасан хувьцааг нийтэд нээлттэй худалдахын өмнө тус компанийн хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлсүгэй.

6. Энэ тогтоолын 5-д заасан тэргүүн ээлжинд худалдан авах саналыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш ажлын 30-аас доошгүй хоногийн хугацаанд хүлээн авах, улмаар хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах арилжааг нэгдсэн журмаар зохион байгуулж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/, “Бидисек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 2, 3-т заасан хувьцааг зээлдүүлэгчээс бусад хувьцаа эзэмшигч худалдан авсан тохиолдолд уг хөрөнгийг зээлдүүлэгчид ажлын 20 хоногийн дотор шилжүүлж холбогдох тооцоог хийж дуусгахыг “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 4-т заасан нэмж гаргаж буй хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг өмнө гаргасан хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаанаас тусд нь зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааг энэхүү тогтоолын 6-д заасан хугацаанаас хойш 30 хоногт багтаан дуусгах, хувьцаа борлуулсны орлогыг “Хай би ойл” ХК-ийн дансанд байршуулж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/, “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/, “Бидисек” ХК /Д.Даянбилгүүн/-д нарт тус тус үүрэг болгосугай.

9. “Хай би ойл” ХК-ийн дүрмийн санг 223.426.800 /хоёр зуун хорин гурван сая дөрвөн зуун хорин зургаан мянга найман зуун/ төгрөгөөр нэмэгдүүлэх, хувьцаа нэмж гаргасантай холбогдуулан компанийн санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль, стандартийн дагуу өөрчлөлт оруулахыг “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

10. Нэмж гаргах хувьцааны танилцуулгыг зохих журмын дагуу баталгаажуулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т, баталгаажуулсан танилцуулгад тус Хорооны зөвшөөрөлгүй аливаа өөрчлөлт хийхгүй байх, энэ тогтоолын 6-д заасан хугацаанд олон нийтэд үнэ төлбөргүйгээр танилцуулж, өөрийн байгууллагын веб хуудсанд байнга байршуулж

ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/, “Бидисек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

11. Өрийг хувьцаагаар солих ажиллагааг хэрэгжүүлж дууссанаас хойш гүйцэтгэлийн тайланг 30 хоногийн дотор тус Хороонд ирүүлэх, мөн уг тайланг нийтэд мэдээлэхийг “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

12. Цаашид хувьцаанд хөрвөх нөхцөлтэйгөөр бусдаас аливаа санхүүжилт авч өр үүсгэхээс өмнө асуудлыг урьдчилан Хороонд танилцуулан шийдвэрлүүлж, гарсан шийдвэр, өр төлбөр үүсч буй явцын талаар нийтэд тухай бүр шуурхай мэдээлэхээс гадна өр төлбөрийн гүйлгээг заавал компанийн харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байхыг “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/-д анхааруулсугай.

13. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Хай би ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

14. Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН